



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/492

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "г", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11 дүгээр хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 6 дугаар багийн иргэн Э.Гүндалайд Бодибилдингийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход тусламж 200000 төгрөг, хүнд өвчнөөр нас нөгчсөн Мөрөн сумын өндөр настан Д.Төмөрт 100000 төгрөг, Өндөр настан П.Должинд 200000 төгрөг, хагалгаанд ороход санхүүгийн дэмжлэг хүссэн Цагаан-Үүр сумын 4 дүгээр багийн иргэн Р.Давгадуламд 100000 төгрөг, мөнгөн тусламж хүссэн 6 дугаар багийн иргэн Р.Чанцалд 100000 төгрөг, Эрдэнэбулган сумын иргэн Ч.Уртнасан, Ё.Болорцэцэг нарт тус бүр 50000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх 800000 (Найман зуун мянган) төгрөгийг Засаг дарга ерөнхий дансны иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх зардлаас гаргахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (С.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД